



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж 1-14 дүгээр баг Дархан-Уул
Дархан-Уул аймаг 45059
Утас 7037-3089, Факс (976) 7037-3089
Цахим шуудан darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас www.audit.mn

2025.02.03 № 23
ганай 2025.01.16 -ны № 1/69

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.БОЛД-ЭРДЭНЭ
ТАНАА**

Дархан-Уул аймгийн Прокурорын
газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан,
гэрчилгээ хүргүүлэв.



Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар
Удирдлага
Дарга
Ш.Мөнхбаяр
2025.02.03 08:56



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/12/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Б.Алтанзул

Утас: 70373089 Цахим хаяг: altanzulby@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХ	Хөрөнгө
Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө	
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.03 № 23
танай 2025.01.26 -ны № 7/69 -г

ДАРХАН -УУЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.БОЛД-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Ерөнхий прокурорын 2024 оны А/105, А/116, А/165 дугаар тушаалаар 16,574.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, Ерөнхий прокурорын 2024 оны А/100 дугаар тушаалаар Мал эмнэлгийн ерөнхий газарт 22,000.0 мянган төгрөгийн автомашиныг шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Их хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 117 дугаар тогтоолоор прокурорын цалинг дунджаар 136.4 хувиар нэмэгдүүлснээр цалингийн зардал өнгөрсөн оноос 74.5 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Прокурорын газар 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын 65 арга хэмжээ төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба Ерөнхий прокурорын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хэрэгжилтийг "Хангалттай" гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

009020007

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,933,076.00	50,565,208.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,933,076.00	50,565,208.00
354	Хангамжийн материал	16,933,076.00	50,565,208.00
35410	Бичиг хэргийн материал	384,500.00	1,610,900.00
35420	Аж ахуйн материал	13,045,200.00	24,491,310.00
35440	Түлш, шатах тослох материал	20,816.00	20,192.00
35470	Бусад хангамжийн материал	3,482,560.00	24,442,806.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	795,879,323.42	758,068,712.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	795,879,323.42	758,068,712.17
392	Биет хөрөнгө	723,001,223.42	685,163,112.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	654,014,440.00	654,014,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(105,067,767.00)	(128,675,606.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,800,000.00	54,766,666.59
39204	Хуримтлагдсан элэгдэл	(55,524,999.95)	(48,120,555.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,214,283.86	178,413,572.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(71,357,450.52)	(81,448,012.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,562,613.45	65,222,162.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,676,141.22)	(22,110,875.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,850,290.00	21,850,290.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,814,045.20)	(8,748,970.24)
393	Биет бус хөрөнгө	72,878,100.00	72,905,600.00
39301	Програм хангамж	1,320,000.00	1,710,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(522,500.00)	(885,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	72,080,600.00	72,080,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	812,812,399.42	808,633,920.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	812,812,399.42	808,633,920.17
51	Засгийн газрын хувь оролцоо	812,812,399.42	808,633,920.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	986,906,485.52	986,906,485.52
51101	Өмч: - төрийн	986,906,485.52	986,906,485.52
512	Хуримтлагдсан үр дүн	(195,944,376.10)	(212,121,020.76)
51210	Өмнөх үеийн үр дүн	(154,363,092.96)	(208,859,208.10)
51220	Тайлант үеийн үр дүн	(41,581,283.14)	(4,178,479.25)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,850,290.00	34,765,122.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	812,812,399.42	808,633,920.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,094,856,730.00	1,944,316,529.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,821,130.00	39,451,029.59
120	Нийтлэг татварын бус орлого	9,821,130.00	39,451,029.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,821,130.00	39,451,029.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,821,130.00	39,451,029.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,085,035,600.00	1,904,865,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,495,000.00	22,950,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,495,000.00	22,950,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих	1,074,540,600.00	1,881,915,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,074,540,600.00	1,881,915,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,136,438,013.14	1,947,578,342.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,136,438,013.14	1,947,578,342.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,129,706,606.59	1,838,936,787.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,689,067.00	1,472,408,339.00
210101	Үндсэн цалин	462,610,179.00	808,099,945.00
210102	Нэмэгдэл	230,253,667.00	442,850,565.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,290,000.00	111,250,000.00
210104	Урамшуулал	96,535,221.00	110,207,829.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,893,822.59	183,936,043.99
210201	Тэтгэврийн даатгал	70,149,079.29	125,149,340.04
210202	Тэтгэмжийн даатгал	8,252,828.23	14,700,591.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,549,453.17	7,351,826.12
210204	Ажилгүйдлийн даатгал	1,632,320.60	7,346,858.84
210205	Эрүүл мэндийн даатгал	16,310,141.30	29,387,427.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,104,243.04	20,096,736.88
210301	Гэрэл, цахилгаан	8,544,224.56	10,244,175.52
210302	Түлш, халаалт	8,940,668.62	6,167,891.40
210303	Цэвэр, бохир ус	3,619,349.86	3,684,669.96
2104	Хангамж, бараа материалын зардал	35,919,375.82	35,264,385.41
210401	Бичиг хэрэг	10,312,900.00	13,273,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,870,060.00	10,848,524.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,477,725.82	6,181,121.41
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	615,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,018,690.00	4,346,740.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,996,858.00	21,448,000.00
210604	Урсгал засвар	18,996,858.00	21,448,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,877,887.00	11,537,500.00
210702	Дотоод албан томилолт	9,877,887.00	11,537,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,198,000.00	4,249,543.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,797,500.00	3,829,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,600.00	199,128.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	153,900.00	177,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,027,353.14	89,996,239.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,596,000.00	9,341,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,431,353.14	79,554,739.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,731,406.55	108,641,554.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,800,000.00	58,632,335.84
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		53,662,335.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,800,000.00	4,970,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	931,406.55	50,009,218.88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	931,406.55	50,009,218.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(41,581,283.14)	(3,261,812.66)
	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	=	=
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал- Үндсэн хөрөнгө		(916,666.59)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(41,581,283.14)	(4,178,479.25)

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2023 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	986,906,485.52	21,850,290.00	(154,363,092.96)		854,393,682.56
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-				
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	986,906,485.52	21,850,290.00	(154,363,092.96)		854,393,682.56
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-				
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-				
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-				
S07	Тайлант үеийн үр дүн	-		(41,581,283.14)		(41,581,283.14)
S08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	986,906,485.52	21,850,290.00	(195,944,376.10)		812,812,399.42
D01	2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	986,906,485.52	21,850,290.00	(195,944,376.10)		812,812,399.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	986,906,485.52	21,850,290.00	(208,859,208.10)		799,897,567.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-		(4,178,479.25)		(4,178,479.25)
D08	Тайлант үеийн үр дүн	-				
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	986,906,485.52	21,850,290.00	(200,122,855.35)		808,633,920.17

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар

ХТ03439 @ 9622899

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,085,035,600.00</u>	<u>1,904,865,500.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,085,035,600.00	1,904,865,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,495,000.00	22,950,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,495,000.00	22,950,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих	1,074,540,600.00	1,881,915,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,074,540,600.00	1,881,915,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,054,167,100.00</u>	<u>1,880,695,489.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,054,167,100.00	1,880,695,489.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,047,435,693.45	1,772,053,934.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	843,688,269.12	1,473,460,097.00
210101	Үндсэн цалин	443,825,712.00	789,767,464.00
210102	Нэмэгдэл	260,689,942.12	451,595,036.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,464,687.00	113,708,771.00
210104	Урамшуулал	86,707,928.00	118,388,826.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,894,620.47	182,884,285.99
210201	Тэтгэврийн даатгал	70,958,366.00	124,378,048.49
210202	Тэтгэмжийн даатгал	8,348,105.47	14,632,694.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,643,364.00	7,316,395.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,655,698.00	7,311,728.61
210205	Эрүүл мэндийн даатгал	15,289,087.00	29,245,418.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,104,243.04	20,096,736.88
210301	Гэрэл, цахилгаан	8,544,224.56	10,244,175.52
210302	Түлш, халаалт	9,027,885.82	6,167,891.40
210303	Цэвэр, бохир ус	3,532,132.66	3,684,669.96
2104	Хангамж, бараа материалын зардал	35,164,215.82	40,442,671.41
210401	Бичиг хэрэг	10,300,000.00	13,499,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,886,500.00	11,847,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,477,725.82	6,181,121.41
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	615,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,199,990.00	8,299,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,492,458.00	16,857,000.00
210601	Багаж техник хэрэглэл	75,000.00	-
210604	Урсгал засвар	18,417,458.00	16,857,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,877,887.00	11,537,500.00
210702	Дотоод албан томилолт	9,877,887.00	11,537,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,398,000.00	10,013,543.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,997,500.00	9,593,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,600.00	199,128.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	-	-
210807	Газрын төлбөр	153,900.00	177,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,816,000.00	16,762,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,816,000.00	15,662,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,731,406.55	108,641,554.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,800,000.00	58,632,335.84
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		53,662,335.84
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,800,000.00	4,970,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	931,406.55	50,009,218.88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	931,406.55	50,009,218.88
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,868,500.00</u>	<u>24,170,011.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	30,868,500.00	24,170,011.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,868,500.00	24,170,011.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,868,500.00	24,170,011.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	30,868,500.00	24,170,011.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(30,868,500.00)</u>	<u>(24,170,011.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,881,915,500.00	1,831,906,981.12	50,008,518.88	97.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,881,915,500.00	1,831,906,981.12	50,008,518.88	97.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,823,283,000.00	1,773,274,645.28	50,008,354.72	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,518,367,800.00	1,473,460,097.00	44,907,703.00	97.0
210101	Үндсэн цалин	793,263,700.00	789,767,464.00	3,496,236.00	99.6
210102	Нэмэгдэл	463,999,300.00	451,595,036.00	12,404,264.00	97.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	121,094,400.00	113,708,771.00	7,385,629.00	93.9
210104	Урамшуулал	140,010,400.00	118,388,826.00	21,621,574.00	84.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,796,800.00	182,884,285.99	3,912,514.01	97.9
210201	Тэтгэврийн даатгал	119,796,800.00	124,378,048.49	(4,581,248.49)	103.8
210202	Тэтгэмжийн даатгал	24,718,700.00	14,632,694.70	10,086,005.30	59.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,046,900.00	7,316,395.89	(269,495.89)	103.8
210204	Ажилгүйдлийн даатгал	7,046,900.00	7,311,728.61	(264,828.61)	103.8
210205	Эрүүл мэндийн даатгал	28,187,500.00	29,245,418.30	(1,057,918.30)	103.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,061,700.00	20,096,736.88	964,963.12	95.4
210301	Гэрэл, цахилгаан	10,999,900.00	10,244,175.52	755,724.48	93.1
210302	Түлш, халаалт	7,050,300.00	6,167,891.40	882,408.60	87.5
210303	Цэвэр, бохир ус	3,011,500.00	3,684,669.96	(673,169.96)	122.4
2104	Хангамж, бараа материалын зардал	40,626,400.00	40,442,671.41	183,728.59	99.5
210401	Бичиг хэрэг	13,500,000.00	13,499,400.00	600.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	11,847,900.00	11,847,900.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,178,500.00	6,181,121.41	(2,621.41)	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	615,000.00	185,000.00	76.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,300,000.00	8,299,250.00	750.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,360,000.00	21,347,711.00	12,289.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,490,711.00	9,289.00	99.8
210604	Урсгал засвар	16,860,000.00	16,857,000.00	3,000.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	11,540,000.00	11,537,500.00	2,500.00	100.0
210702	Дотоод албан томилолт	11,540,000.00	11,537,500.00	2,500.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,426,200.00	10,403,543.00	22,657.00	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00	9,983,300.00	16,700.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,700.00	199,128.00	3,572.00	98.2
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	179,500.00	177,115.00	2,385.00	98.7

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,104,100.00	13,102,100.00	2,000.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,002,100.00	12,002,100.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,102,000.00	1,100,000.00	2,000.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,632,500.00	58,632,335.84	164.16	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,632,500.00	58,632,335.84	164.16	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,662,500.00	53,662,335.84	164.16	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00	0.00	#DIV/0!
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,970,000.00	4,970,000.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00	0.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,881,915,500.00	1,831,906,981.12	50,008,518.88	97.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,881,915,500.00	1,831,906,981.12	50,008,518.88	97.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,881,915,500.00	1,831,906,981.12	50,008,518.88	97.3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	31	1	103.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18	19	1	105.6
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.0

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/		
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,950,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,949,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,949,300.00
2106	Эд хогшил худалдан авах	17,000,000.00
210601	Багаж техник хэрэглэл	17,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,949,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,949,300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,950,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,950,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,950,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцохдоо хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах эрх зорилго бүхий, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

Тус байгууллага нь 2024 онд Улсын Ерөнхий Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын дагуу Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх, Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах, Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох, Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах гэсэн зорилтуудыг дэвшүүлснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Прокурорын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Прокурорын газар 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Ерөнхий прокурорын 2021 оны А/179 тоот тушаалаар Прокурорын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн, 2023 оноос мөрдөж ажилласан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,261.8 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	16,933.1	50,565.2	33,632.1
Үндсэн хөрөнгө	795,879.3	758,985.4	(36,893.9)
Нийт хөрөнгө	812,812.4	809,550.6	(3,261.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	812,812.4	809,550.6	(3,261.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	812,812.4	809,550.6	(3,261.8)

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын дансны үлдэгдэл 33,632.1 мянган төгрөгөөр өссөн нь Ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар 20,044.6 мянган төгрөгийн прокурорын дүрэмт хувцас, тусгай хэрэгслийг, Ерөнхий прокурорын 2024 оны А/191 тоот тушаалаар 915.6 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч, төсвийн хөрөнгөөр 69,380.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 56,708.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 758,985.4 мянган төгрөг болж буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,848.1 мянган төгрөгийн, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 37 дугаар тогтоолын дагуу 18,321.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, Ерөнхий прокурорын 2024 оны А/105, А/116, А/165 дугаар тушаалаар 16,574.7 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, Ерөнхий прокурорын 2024 оны А/204 дугаар тушаалаар 1,916.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж орлогод авч, харин Ерөнхий прокурорын 2024 оны А/100 дугаар тушаалаар 22,000.0 мянган төгрөгийн үнэтэй автомашиныг Мал эмнэлгийн ерөнхий газарт шилжүүлэн, А/203 дугаар тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 25,459.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталж тайлант онд 79,554.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан зэргээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Прокурорын газар 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 1,121,600.0 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг 100 хувь улсын төсвөөр бүрдүүлэхээр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 11,442.3 мянган төгрөгөөр өсгөж, 1,133,042.3 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд батлагдсан төсвийг Улсын ерөнхий прокурорын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/195 дугаар тушаалаар 748,873.2 мянган төгрөгөөр нэмж, 1,881,915.5 мянган төгрөг болгож тодотгожээ. Үүнд прокурорын үндсэн цалинг дунджаар 136.4 хувиар нэмэгдүүлснээр цалингийн зардал, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 673,826.6 мянган төгрөг, бараа материал бэлтгэхтэй холбоотойгоор хангамж бараа материалын зардлыг 9,977.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 11,700.0 мянган төгрөг, томилолтын зардлыг 7,340.0 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардлыг 2,174.2 мянган төгрөг, 2 албан хаагч тэтгэвэрт гарахтай холбоотойгоор нэг удаагийн тэтгэмж 58,632.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, тогтмол зардлыг 14,778.0 мянган төгрөгөөр бууруулсан нь нөлөөлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэх 1,881,915.5 мянган төгрөгийг 100 хувь улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 1,831,906.9 мянган төгрөгийг зарцуулж, 50,008.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,831,906.9 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь албан хаагчдын үр дүнгийн урамшлыг ажлын гүйцэтгэлд үндэслэн тооцож олгосноор цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардал 48,820.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 964.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70703- Прокурорын хяналт	1,881,915.5	1,831,906.9	(50,008.5)	97.3
	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	1,813,283.0	1,763,291.3	(49,991.6)	97.2
	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	58,632.5	58,632.3	0.2	100.0
3	82315- Байцаан шийтгэх ажиллагаа	10,000.0	9,983.3	16.7	99.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 35, 36, 37 дугаар тогтоолуудын дагуу “Иргэн танд” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулахад 1,300.0 мянган төгрөгийн, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд залуучуудын оролцоо” эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд 2,000.0 мянган төгрөгийн, мөн тус газрын дэргэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр видео контент хийх студи байгуулахад 19,650.0 мянган төгрөгийн, нийт 22,950.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний зардал, үндсэн хөрөнгө худалдан авахад зориулалтын дагуу зарцуулж 0.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Шилэн дансны тухай хуультай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Алтанзул гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Прокурорын газар 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/69 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ. Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 1,881,915.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,819.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан хаагчдын үр дүнгийн урамшлыг хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д заасны дагуу ажлын үр дүнтэй нь уялдуулан тооцож олгосноор цалингийн зардлын 48,820.2 мянган төгрөгөөр, байр ашиглалтын зардлыг 964. 9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдох мэдээллийг бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус Прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,049.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	923.3	1	923.3	100%
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	1	923.3	1	923.3	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,977.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны зарцуулалтыг шалгахад 3,977.0 мянган төгрөгийн бараа материалыг тайлант үеийн зардлаар тайлагнасан нь УСНББОУС-12 “Бараа материал”

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

стандарт, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул санхүүгийн тайланд бараа материал дансанд бүртгэж залруулав.

Мөн аудитаар илэрсэн 10,607.3 мянган төгрөгийн зөрчил²-д цаашид үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайланд оны 12 дугаар сард батлагдсан орон тоог 1 орон тоогоор хэтрүүлэн ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т *“Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид батлагдсан орон тоог баримталж ажиллах.

1.2 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 17 албан хаагчийн 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг нэмэгдсэн цалингаас тооцсоноос 10,607.3 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2-т *“Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төрийн албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшууллыг тооцож олгохдоо тухайн хугацаанд тогтоосон үндсэн цалингаас тооцож олгох.

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³д заасны дагуу ирүүлэх, зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлаар бүртгэсэн 3,977.0 мянган төгрөгийн бараа материалыг холбогдох дансанд бүртгэх	1	3,977.0	-	-	1	3,977.0	1	3,977.0	-	-	-	-
Дүн	1	3,977.0	-	-	1	3,977.0	1	3,977.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны Тоо	Тоо	Дүн
Батлагдсан орон тоог баримталж ажиллах	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Төрийн албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшууллыг тооцож олгохдоо тухайн хугацаанд тогтоосон үндсэн цалингаас тооцож олгох	1	10,607.3	-	-	-	-	1	10,607.3	-	-	-	-
Дүн	2	10,607.3	-	-	-	-	2	10,607.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжлттэй холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-